

Аймгийн Засаг даргын 2020 оны 05
дугаар сарын 07-ны өдрийн 111 дугаар
захирамжийн хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН 2020 ОНЫ
“ХӨРӨНГӨ ГАРГАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ” А/106 ДУГААР
ТУШААЛААР ЭРХ ШИЛЖСЭН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ АЖЛЫН
ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

Д/ д	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг сая/төг
1	Арвайхээр сумын төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах торон хашаа барих, тохижилтын ажил	10 000 000
	Төвлөрсөн хогийн цэгийн хойд хэсгээр улиас мод тарих	6 000 000
	Цэвэрлэх байгууламжийн лаг, малын гаралтай хог хаягдал булшлах талбай бэлтгэх	3 500 000
2	Арвайхээр сумын агаарын чанар сайжруулах бүс дэх агаар бохирдуулагч эх үүсвэрийн нарийвчилсан судалгаа, тооллого явуулах	9 000 000
	“Хандлагаа өөрчилье” аяны хүрээнд Арвайхээр сумын цэцэрлэгт хүрээлэнгүүд, нийтийн эзэмшлийн зам талбайн их цэвэрлэгээ зохион байгуулах,	4 500 000
3	Сургалт, сурталчилгаа хийх, гарын авлага, зөвлөмж боловсруулах, олон нийтэд хүргэх	4 000 000
4	Арвайхээр сумын хогийн нэгдсэн цэгт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх	13 000 000
Дүн		50 000 000



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/236

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны “Хөрөнгө гаргах эрх шилжүүлэх тухай” А/106 дугаар тушаалын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төвийн орчны бохирдол хатуу хог хаягдлыг бууруулах, төвлөрсөн хогийн цэгийг тохижуулах, хашаажуулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх, “Хандлагаа өөрчилъе” аяныг үргэлжлүүлэн зохион байгуулахад 50,000,000 (тавин сая) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан арга хэмжээг зохион байгуулж тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Т.Ариунболд) тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100531